



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/154

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 31 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуулийн дотуур байрыг холбогдох журмын дагуу бэлэн байдлыг ханган, тусгаарлан ажиглах байраар ажиллуулахыг Сумдын Засаг дарга, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

2. Тусгаарлан эмчлэх эмнэлэг болон тусгаарлан ажиглах байранд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, халдваргүйтгэлийн бодисын 14-өөс дээш хоногийн нөөцийг бүрдүүлэн, бэлэн байдлыг хангахыг Сумдын Онцгой комисс, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус даалгасугай.

3. Тусгаарлан эмчлэх болон тусгаарлан ажиглах байранд ажиллах хүн хүчний нөөцийг төлөвлөн, томилгоог хийж захирамжаар баталгаажуулах, ажиллах эрүүл мэндийн ажилтан, бусад төрийн албан хаагчдад "Хамгаалах хувцас хэрэглэлийг зөв өмсөх, тайлах", "Халдвараас урьдчилан сэргийлэх" зэрэг сургалтыг зохион байгуулан, дадлагажуулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, гадна болон дотор талыг телекамераар хянах, ногоон бүсэд ажиллах албан хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг Сумдын онцгой комисст чиглэл болгосугай.

4. Хил залгаа аймаг, сумдад отроор яваа малчдын судалгааг гаргаж, амьсгалын замаар дамжих халдвар илрүүлэх тандалтыг хийж, мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга болон Эрүүл мэндийн төвийн дарга нарт хариуцуулсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

481210427